



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Иргэний хөдөлгөөний намын
дүрмийн өөрчлөлтийг улсын
бүртгэлд бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Г.Банзрагч, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батзориг, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, С.Соёмбо-Эрдэнэ, П.Соёл-Эрдэнэ, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Иргэний хөдөлгөөний намын дарга Ө.Баяраагийн гаргасан “Үндсэн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт бүртгүүлэх тухай” өргөдлийг шүүгч Ц.Цогтын илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг.Иргэний хөдөлгөөний намын дарга Ө.Баяраа “Улс төрийн намын тухай хууль, намын үндсэн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Иргэний хөдөлгөөний намын Ээлжит бус III Иргэний Бага Чуулганыг зарлан хуралдуулж, намын үндсэн дүрмийн Нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 3.1, 3.3, 3.4, 3.5, 3.6, Гуравдугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.2, 8 дугаар зүйлийн 8.4, Дөрөвдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 1.2-т тус тус өөрчлөлт оруулсныг Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын дагуу хүргүүлж байна. Иймд намын үндсэн дүрэмд оруулсан өөрчлөлтийг зохих журмын дагуу бүртгэж өгнө үү” гэсэн хүсэлт бүхий өргөдөл гаргасан. Өргөдөлдөө:

-Улс төрийн зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Ээлжит бус Иргэний 3 дугаар Бага Чуулганыг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлын санал гаргах тухай” 01 дүгээр тогтоол,

-Намын даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Ээлжит бус Иргэний 3 дугаар Бага Чуулганыг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлын санал гаргах тухай” 01 дүгээр тушаал,

-Иргэний Бага Чуулганы 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэл,

-Ээлжит бус Иргэний 3 дугаар Бага Чуулганы хуралдааны бүрэн эрхийг баталгаажуулах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 01 дүгээр Иргэний Бага Чуулганы тогтоол,

- Тэргүүлэгчдийг батлах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Тооллогын комиссыг батлах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Редакцын комиссыг батлах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Хуралдааны дэг батлах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Хэлэлцэх асуудал, түүний дарааллыг батлах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Үндсэн дүрэмд өөрчлөлт оруулах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Намын бэлгэ тэмдэг, туг, далбааны загвар батлах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Намын бэлгэ тэмдэг, туг, далбааны загвар батлах тухай 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Ээлжит бус 3 дугаар Иргэний Бага Чуулганы товыг зар хүргэсэн байдал,
- Хурлын ирцийн бүртгэл,
- Иргэний Бага Чуулганы гишүүдийг батлах тухай 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 09 дүгээр Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Иргэний Бага Чуулганы гишүүдийг батлах тухай 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр Иргэний Бага Чуулганы тогтоол,
- Улсын бүртгэлийн гэрчилгээ /Эх хувь/ болон бусад холбогдох баримтыг хавсарган ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Иргэний хөдөлгөөний намын Иргэний Бага Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 7 дугаар тогтоолоор тус намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хууль болон тус намын дүрэмд нийцсэн тул дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээр шийдвэрлэв.

Нэг. Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 6 дугаар зүйлийн 6.1-д “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухайн шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор намын дарга, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч журмын №5, 5А-д заасан бүрдлийг хангаж Улсын дээд шүүхэд хүргүүлнэ” гэж заасны дагуу 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдөр тус намын Иргэний Бага Чуулганы хуралдаанаар шийдвэрлэсэн намын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр намын дарга Ө.Баяраа 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр өргөдөл гаргажээ.

Улсын дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Иргэний хөдөлгөөний намыг улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд тус шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор намын даргаар Ө.Баярааг бүртгэсэн бүртгэл хүчин төгөлдөр байна.

Иргэний хөдөлгөөний намын дүрмийн 6 дугаар зүйлд “Иргэний Бага Чуулганы бүрэн эрх”, 6.1-д “Намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, дүрэмд оруулах

нэмэлт, өөрчлөлтийг батлах” гэж заасан нь тус намын удирдах дээд байгууллага болох Иргэний Бага Чуулганы бүрэн эрхэд хамаарна. Намын Иргэний Бага Чуулган дүрэмд заасны дагуу дараах журмаар хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргажээ.

Улс төрийн зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Ээлжит бус Иргэний 3 дугаар Бага Чуулганыг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлын санал гаргах тухай” 01 дүгээр тогтоол, Намын даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Ээлжит бус Иргэний 3 дугаар Бага Чуулганыг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлын санал гаргах тухай” 01 дүгээр тушаалыг үндэслэн Иргэний Бага Чуулганыг хуралдуулсан нь тус намын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Иргэний Бага Чуулганы хуралдаан ээлжит болон ээлжит бус байж болно ...”, 5.2-т “Хурлын товыг Улс Төрийн Зөвлөлийн саналыг үндэслэн намын дарга тогтоох ба хурал болохоос хоёр долоо хоногийн өмнө гишүүдэд зарлана” гэж тус тус заасантай нийцжээ.

Иргэний хөдөлгөөний намын дүрмийн 4.2-т “Иргэний Бага Чуулган нь 180 хүртэл гишүүнтэй байна”, 6 дугаар зүйлд “Иргэний Бага Чуулганы бүрэн эрх”, 6.2-т “Иргэний Бага Чуулганы гишүүдийг сонгох, чөлөөлөх” гэж тус тус заасны дагуу Намын Иргэний Бага Чуулганы 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 135 гишүүний нэрс, 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 33 буюу нийт 168 Иргэний Бага Чуулганы гишүүнтэй байхаар баталсан байна.

Иргэний Бага Чуулган 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж, 168 гишүүдээс хуралд 134 нь оролцож нийт төлөөлөгчийн 100 хувийн саналаар намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн нь (хуралдааны тэмдэглэл, гишүүдийн бүртгэл, тооллогын комиссын дүн, фото зураг зэрэг баримтаар нотлогдоно) дүрмийн 5.8-д “... Иргэний Бага Чуулганы гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогсдын олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.” гэж заасантай тус тус нийцжээ.

Хоёр. Тус намын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Иргэний Бага Чуулган нь Иргэний Их Чуулганы чөлөөт цагт үйл ажиллагаа явуулах намын эрх барих удирдах дээд байгууллага бөгөөд намын улс төрийн бодлого боловсруулах үндсэн үүрэгтэй” гэж заажээ. Иргэний Бага Чуулганы хурлын 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 7 дугаар тогтоолоор намын дүрмийн дараах заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:”, 17.2.1-д “намын дүрэм ... батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасантай нийцсэн байна. Үүнд:

Намын дүрмийн нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлд “Намын туг, бэлгэдэл, албан хуудас, тамга” гэснийг “Намын бэлгэ тэмдэг, туг, далбаа, уриа, албан хуудас, тамга” гэж,

Нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Нам Үндсэн дүрмээрээ тодорхойлогдсон туг, бэлгэдэлтэй байна” гэснийг “Нам үндсэн дүрмээрээ тодорхойлогдсон бэлгэ тэмдэг, туг, далбаа, уриа, албан хуудас, тамгатай байна” гэж,

3 дугаар зүйлийн 3.3-т “Намын тугийн өргөн, урт нь 1:2 харьцаатай байна. Туг нь тод шар өнгийн дэвсгэр дээр тод хөх өнгөөр “Иргэний хөдөлгөөний” нам гэж бичсэн байна” гэснийг “Монгол хүн, Монгол үндэстний түүхэн үнэнийг томьёолон утгачилж илэрхийлсэн үнэт зүйлсийг дээдлэн авч намын үйл хэрэг болоод гишүүдийнхээ итгэл үнэмшил, эв нэгдлийн илэрхийлэл болгон бэлгэ тэмдэгтээ тусгана. Намын бэлгэ тэмдэг нь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ. Дээд хэсэгт гэрэл сүүдрийг хэм тэнцүүлэх Их шонхрын буулт, дунд хэсэгт түмэн насан хээг, доод хэсэгт ирэх цагийн Их ерөөлийг худам Монгол бичгээр бичсэн байна. Бэлгэ, тэмдгийн өргөн, өндрийн хэмжээс 1:3.7 харьцаатай байна. Шонхор түмэн насан хээ нь улаан, гэрлийн дүрслэл нь дугуй тойрогт алтан шар байна. Өлзий хээ, сүүдэр, ерөөлийн бичээс нь хар өнгөтэй байна. Гэрлийн дотор талын дээд хэсэгт өлзий хээг байрлуулсан байна” гэж,

3 дугаар зүйлийн 3.4-т “Намын бэлгэдэл нь алтан нарыг бэлгэдсэн шар өнгийн дугуй дэвсгэр дээр Иргэний хөдөлгөөний намын товчлол ИХ гэж томоор бичээд /томоор бичсэн Х үсгийн тал нь дугуй дэвсгэрийн гадна талд бичигдэнэ/, дор нь нам гэж жижгээр /жижгээр бичсэн м үсэг нь дугуй дэвсгэрийн гадна талд бичигдэнэ/ бичсэн байна” гэснийг “Их төрийн сүр сүлдэн дор намын тугаа босгож, үйл хэргийн нэгдмэл сүр хүчээ илтгэн өргөнө. Намын туг нь гурвалжин буюу аранжин хэлбэртэй, нил ягаан хөх өнгийн дэвсгэртэй, өндөр нь 90 см, хажуу талуудын урт нь 108 см байна. Туган дээр намын бэлгэ тэмдгийг байрлуулсан байна” гэж,

3 дугаар зүйлийн 3.5-д “Намын нэр, туг, бэлгэдэл, албан бичгийн хуудас, тамга, тэмдгийг хэрэглэх журмыг ИБЧ-аас тогтооно” гэснийг “Намын туг дор намын далбаагаа босгож, үйл ажиллагаандаа бүхий л хүнтэй үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, итгэл үнэмшил, үзэл бодол, боловсролын зөрүүгээс үл хамааран ойлгон ухаарч, танин мэдэж, хүндэтгэн харьцах ёстой үнэнийг ёсчлон өргөнө. Намын далбаа нь босоо дөрвөлжин хэлбэртэй байна. Хөх, хар, цагаан, ногоон, улаан өнгө бүхий 5 далбаанаас бүрдэнэ. Далбаа нь 135 см өндөртэй, 54 см өргөнтэй байна. Далбаан дээр худам Монгол бичгээр Иргэний Хөдөлгөөний нам гэж алтлаг шар өнгөөр бичсэн байна” гэж,

Гуравдугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Иргэний Бага Чуулган нь 180 хүртэл гишүүнтэй байна” гэснийг “Иргэний Бага Чуулган нь 333 хүртэл гишүүнтэй байна” гэж,

8 дугаар зүйлийн 8.4-т “Улс Төрийн Зөвлөл нийт 25 хүртэл гишүүнтэй байна” гэснийг “Улс Төрийн Зөвлөл нийт 33 хүртэл гишүүнтэй байна” гэж,

Дөрөвдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “Хяналтын Ерөнхий Зөвлөлийг Иргэний Их Чуулганаас 5-7 хүртэл гишүүнтэй, аймаг, нийслэл, дүүргийн Хяналтын зөвлөлийг тэдгээрийн иргэдийн бага хурлаас 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаагаар тус тус сонгоно. Намын анхан шатны байгууллагуудын дэргэдэх хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаагаар сонгоно” гэснийг “Хяналтын Ерөнхий Зөвлөлийг Иргэний Их Чуулганаас 5-9 хүртэл гишүүнтэй, аймаг, нийслэл, дүүргийн Хяналтын зөвлөлийг тэдгээрийн иргэдийн бага хурлаас 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаагаар тус тус сонгоно.

Намын анхан шатны байгууллагуудын дэргэдэх хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаагаар сонгоно” гэж тус тус өөрчилж,

Мөн нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.6-д “Намын нэр, бэлгэ тэмдэг, туг, далбааны загварыг ИБЧ-аас, хэрэглэх, тайлбарлах журмыг Улс Төрийн Зөвлөлөөс тогтооно” гэж нэмсэн.

Түүнчлэн тус намын Иргэний Бага Чуулганы 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 08, 10 дугаар тогтоолоор баталсан намын бэлгэ тэмдэг, туг, далбааны загварыг Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бусад намын бэлгэ тэмдэгтэй ижил төсөөтэй эсэхийг харьцуулан судалж үзэхэд Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасныг зөрчөөгүй байна.

Иймд Иргэний хөдөлгөөний намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д заасныг баримтлан Иргэний Бага Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 7 дугаар тогтоолоор баталсан Иргэний хөдөлгөөний намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

Ц.ЦОГТ